



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХОА-2024/157/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Балжинням Утас: 99434344 Цахим хаяг: baljinnyamd@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

---

ЧАНДМАНЬ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ш.ПҮРЭВДАМБА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар харилцагч байгууллагуудтай зардлын санхүүжилтийн тооцоог тулган баталгаажуулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжих байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын данснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлыг санхүүжүүлсэн, бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийгээгүй, бараа материалын өртгийн бүртгэлийг үнэн зөв илэрхийлээгүй зэрэг алдаа зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 2.6.-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,”; 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.22-д “Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна.”; Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын 2103 дах зардлын эдийн засгийн ангиллын” заалтуудтай нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Чандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь 31,158.5 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдаж, сумын орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс 67,775.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэн авч, тайлант оны эцэст 21,322.3 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлсөн байна.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Чандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 8 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 89.4 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>91,441,870.25</b>	<b>150,570,266.43</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	9,493,726.53	65,954,293.79
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	9,493,726.53	65,954,293.79
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	9,493,726.53	65,954,293.79
31211	Төрийн сангийн харилцах	9,493,726.53	65,954,293.79
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	22,934,079.01	14,525,907.93
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,760,043.28	3,640,992.20
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	20,174,035.73	10,884,915.73
3351	Байгууллагаас авах авлага	17,364,833.73	8,075,713.73
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,809,202.00	2,809,202.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	59,014,064.71	70,090,064.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	644,750.00	620,000.00
35130	Эм боох материал	644,750.00	620,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	58,369,314.71	69,470,064.71
35410	Бичиг хэргийн материал	267,000.00	377,000.00
35420	Аж ахуйн материал	45,744,549.71	47,770,699.71
35460	Хүнсний материал	12,357,765.00	21,322,365.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,936,413,108.50</b>	<b>1,951,236,913.30</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,936,413,108.50	1,951,236,913.30
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,875,478,858.74	1,889,966,913.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,958,639,167.00	1,958,639,167.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(276,665,258.60)	(345,235,142.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	594,451,728.93	672,922,629.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(511,971,898.19)	(514,655,137.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,624,946.47	256,303,616.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	(173,038,605.21)	(179,446,997.09)
39217	Ном	40,438,778.34	41,438,778.34
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	60,934,249.76	61,270,000.00
39301	Програм хангамж	607,000.00	1,057,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(492,750.24)	(607,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	60,820,000.00	60,820,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,027,854,978.75</b>	<b>2,101,807,179.73</b>

Чандмань сумын Сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,259,136.93</b>	<b>1,408,674.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,259,136.93	1,408,674.00
413	<b>Өглөг</b>	2,259,136.93	1,408,674.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,163,384.00	1,163,384.00
4136	<b>Бусад өглөг</b>	180,290.00	245,290.00
41361	Байгууллагад төлөх өглөг	19,200.00	84,200.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	161,090.00	161,090.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,025,595,841.82</b>	<b>2,100,398,505.73</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,025,595,841.82	2,100,398,505.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	627,621,997.00	627,621,997.00
51102	- хувийн	627,621,997.00	627,621,997.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	354,558,700.54	429,361,364.45
51210	Өмнөх үеийн үр дүн	354,558,700.54	354,558,700.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	74,802,663.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,043,415,144.28	1,043,415,144.28
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,027,854,978.75</b>	<b>2,101,807,179.73</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,188,760,009.12</b>	<b>1,707,924,948.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,735,346.12</b>	<b>85,787,148.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	23,735,346.12	85,787,148.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,735,346.12	85,787,148.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,228,563.00	165,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,144,100.00	1,078,548.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,362,683.12	84,542,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,165,024,663.00</b>	<b>1,622,137,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,750,851,000.00	1,406,750,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,750,851,000.00	1,406,750,600.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	412,715,100.00	215,387,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	412,715,100.00	215,387,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,121,992,535.80</b>	<b>1,633,122,284.09</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,121,992,535.80</b>	<b>1,633,122,284.09</b>

Чандмань сумын Сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,050,049,017.80	1,585,402,740.71
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,270,619,430.31	1,021,041,556.64
210101	Үндсэн цалин	947,368,509.33	753,873,631.54
210102	Нэмэгдэл	259,201,434.98	230,255,562.71
210104	Урамшуулал	64,049,486.00	36,912,362.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	174,938,880.33	126,116,355.75
210201	Тэтгэврийн даатгал	120,291,859.18	87,362,965.99
210202	Тэтгэмжийн даатгал	13,747,347.46	10,277,995.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,084,798.80	7,181,886.45
210204	Ажилгүйдлийн даатгал	2,710,963.10	1,744,704.89
210205	Эрүүл мэндийн даатгал	27,103,911.79	19,548,802.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	329,325,646.10	213,590,006.62
210301	Гэрэл, цахилгаан	9,426,500.10	33,334,006.62
210302	Түлш, халаалт	319,206,714.00	179,256,000.00
210303	Цэвэр, бохир ус	692,432.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,339,191.00	2,335,936.50
210401	Бичиг хэрэг	5,460,350.00	472,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,878,841.00	1,863,936.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	71,466,102.00	69,734,280.00
210502	Хоол, хүнс	70,920,102.00	69,734,280.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	350,000.00
210604	Урсгал засвар	-	350,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,280,200.00	5,160,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,424,800.00	5,160,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	191,079,568.06	147,074,605.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,770,170.31	30,092,690.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	5,815,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,059,397.75	111,166,515.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	71,943,518.00	47,719,543.38
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	71,898,200.00	47,713,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,898,200.00	47,713,350.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	6,193.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,193.38
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>66,767,473.32</b>	<b>74,802,663.91</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	409,733,352.33	2,080,770,493.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(666,306.70)	(666,306.70)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	409,067,045.63	2,080,104,186.91
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	354,558,700.54	2,025,595,841.82
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	354,558,700.54	2,025,595,841.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	354,558,700.54	2,025,595,841.82
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	74,802,663.91	74,802,663.91
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	429,361,364.45	2,100,398,505.73

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<b>1,302,930,663.00</b>	<b>1,623,382,248.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>4,083,963.00</b>	<b>1,244,448.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	4,083,963.00	1,244,448.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,083,963.00	1,244,448.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,228,563.00	165,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,855,400.00	1,078,548.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>1,298,846,700.00</b>	<b>1,622,137,800.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,045,311,700.00	1,406,750,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,045,311,700.00	1,406,750,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,535,000.00	215,387,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,535,000.00	215,387,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<b>1,293,436,936.47</b>	<b>1,534,763,180.74</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>1,293,436,936.47</b>	<b>1,534,763,180.74</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>1,245,260,918.47</b>	<b>1,487,255,937.36</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	800,931,165.47	1,018,247,924.24
210101	Үндсэн цалин	584,915,305.55	710,285,156.74
210102	Нэмэгдэл	176,418,267.92	263,106,884.50
210104	Урамшуулал	39,597,592.00	44,855,883.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,192,900.00	130,493,600.00
210201	Тэтгэврийн даатгал	68,131,300.00	88,735,800.00

Чандмань сумын Сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	7,944,700.00	10,439,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,483,000.00	8,351,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,603,100.00	2,088,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,030,800.00	20,878,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>212,113,800.00</b>	<b>213,981,006.62</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,895,400.00	8,117,006.62
210302	Түлш, халаалт	204,654,384.00	204,864,000.00
210303	Цэвэр, бохир ус	564,016.00	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>56,669,690.00</b>	<b>80,149,700.00</b>
210502	Хоол, хүнс	56,669,690.00	80,149,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,649,500.00</b>	<b>1,400,000.00</b>
210604	Урсгал засвар	1,649,500.00	1,400,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,207,200.00</b>	<b>5,079,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,855,400.00	274,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,351,800.00	4,805,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,496,663.00</b>	<b>37,904,006.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,468,963.00	26,988,996.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,027,700.00	10,915,010.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,176,018.00</b>	<b>47,507,243.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,130,700.00</b>	<b>47,501,050.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,130,700.00	47,501,050.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>6,193.38</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,193.38
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>9,493,726.53</b>	<b>88,619,067.26</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>32,158,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>32,158,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>32,158,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	32,158,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>=</b>	<b>(32,158,500.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>9,493,726.53</b>	<b>56,460,567.26</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>9,493,726.53</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9,493,726.53</b>	<b>65,954,293.79</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,632,917,600	1,566,915,487
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,632,917,600	1,566,915,487
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,577,818,500	1,519,414,437
2,101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,066,036,700	1,018,247,924
210,101	Үндсэн цалин	728,745,600	710,285,157
210,102	Нэмэгдэл	293,911,300	263,106,885
210,104	Урамшуулал	43,379,800	44,855,883
2,102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	133,254,700	130,493,600
210,201	Тэтгэврийн даатгал	90,613,200	88,735,800
210,202	Тэтгэмжийн даатгал	10,660,400	10,439,400
210,203	ҮОМШӨ-ний даатгал	8,528,300	8,351,500
210,204	Ажилгүйдлийн даатгал	2,132,100	2,088,200
210,205	Эрүүл мэндийн даатгал	21,320,700	20,878,700
2,103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	213,981,900	213,981,007
210,301	Гэрэл, цахилгаан	8,117,900	8,117,007
210,302	Түлш, халаалт	204,864,000	204,864,000
210,303	Цэвэр, бохир ус	1,000,000	1,000,000
2,105	<b>Нормативт зардал</b>	81,610,000	80,149,700
210,502	Хоол, хүнс	81,610,000	80,149,700
2,106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,900,000	1,400,000
210,604	Урсгал засвар	1,900,000	1,400,000
2,108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,611,300	5,079,700
210,801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	274,700	274,700
210,806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,336,600	4,805,000
2,109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	73,423,900	70,062,507
210,901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,419,000	59,147,497
210,902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,004,900	10,915,010
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	55,099,100	47,501,050
2,132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	55,099,100	47,501,050
213,205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,099,100	47,501,050
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,623,429,200	1,623,382,248
1,310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,406,750,600	1,406,750,600

131,001	Улсын төсвөөс санхүүжих	1,406,750,600	1,406,750,600
<b>1,320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	215,887,200	215,387,200
132,001	Орон нутгийн төсвөөс	215,887,200	215,387,200
<b>120,004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	791,400	1,244,448
1,200,041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	274,700	165,900
1,200,042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	516,700	1,078,548
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>9,493,727</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>65,954,294</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	1
610,001	Төсвийн байгууллага		1
620,001	Удирдах ажилтан	-	3
620,002	Гүйцэтгэх ажилтан	-	1
620,003	Үйлчлэх ажилтан	-	1
620,004	Гэрээт ажилтан		1
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	-	1
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	-	1
630,001	Төрийн өмчит ЕБС		1

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 92,780.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 52,113.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Аудитаар 52,113.4 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- БШУЯ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн 26,056.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй,

Эдгээр алдааг залруулснаар санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд өөрчлөлт орж, үр дүнд нөлөөлсөн.

Залруулагдаагүй нийт 40,666.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 40,666.6 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 40,666.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **3.3.1.Тодруулга данстай холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Тайлант онд бусдад өгөх өглөг дансны эцсийн үлдэгдэл 1,408.6 мянган төгрөг, ажиллагсадтай холбоотой авлага 3,640,9 мянган төгрөг, харилцагч байгууллагаас 10,884.9 мянган төгрөгийн авлагын хоорондын тооцоо үүсгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 2.6.-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Харилцагч байгууллагуудтай зардлын санхүүжилтийн тооцоог тулган баталгаажуулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах.

### **3.3.2. Тогтмол зардлын санхүүжилтийн зарцуулалттай холбоотой**

#### **Илрүүлэлт:**

Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын батлагдсан төсвөөс бичиг хэрэг, аж ахуйн хэрэгцээний бараа материалын зардалд 1,066.7 мянган төгрөгийг зориулалт бусаар санхүүжүүлсэн зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын 2103 дах зардлын эдийн засгийн ангиллын заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжих байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын данснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлыг санхүүжүүлэхгүй байх.

### **3.3.3. Бараа материалын данстай холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Тайлант онд 1,203.2 мянган төгрөгийн мах, чацаргана, ногоо зэрэг түргэн муудах хүнсний материалын эхний үлдэгдлийг зарлагадаагүй байгаа нь бараа материалын өртгийн бүртгэлийг зөрчсөн, 21,322.3 мянган төгрөгийн хүнсний бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байгаа зөрчил дутагдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.22-д “Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагадах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагадах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийх, бараа материалын өртгийн бүртгэлийг үнэн зөв илэрхийлэх.

### **3.3.4.Зардлын данстай холбоотой асуудлаар**

Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих зардалд 1,140.0 мянган төгрөгийг зарцуулсан гүйцэтгэлийг үр дүнгийн тайлан байхгүй, анхан баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зардлын гүйцэтгэлд хяналт хийж, анхан шатны баримтыг бүрдүүлэн авч санхүүгийн тайланд хавсаргах

Чандмань сумын Сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Чандмань сумын сургууль	Санхүүгийн тайланд үр дүн дансны нөлөөлөл	1	26,056.7	1	26,056.7			1	26,056.7				
	БШУЯ-с үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг дансанд бүртгээгүй	1	26,056.7	1	26,056.7			1	26,056.7				
<b>Нийт</b>		<b>2</b>	<b>52,113.4</b>	<b>2</b>	<b>52,113.4</b>			<b>2</b>	<b>52,113.4</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хя		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Чандмань сумын сургууль	авлагын хоорондын тооцоо үүсгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	15,934.4.					1	15,934.4			
	байр ашиглалтай холбоотой тогтмол зардлын батлагдсан төсвөөс бичиг хэрэг, аж ахуйн хэрэгцээний бараа материалын зардалд 1,066.7 мянган төгрөгийг зориулалт бусаар санхүүжүүлсэн	1	1,066.7					1	1,066.7			
	Тайлант онд 1,203.2 мянган төгрөгийн мах, чацаргана, ногоо зэрэг түргэн муудах хүнсний материалын эхний үлдэгдлийг зарлагадаагүй байгаа нь бараа материалын өртгийн бүртгэлийг зөрчсөн, 21,322.3 мянган төгрөгийн хүнсний бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй,	1	22,525.5						1	22,525.5		
	Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих зардалд 1,140.0 мянган төгрөгийг зарцуулсан гүйцэтгэлийг үр	1	1,140.0						1	1,140.0		

Чандмань сумын Сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	дүнгийн тайлан байхгүй, анхан баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн									
<b>Нийт</b>		<b>4</b>	<b>40,666.6</b>					<b>4</b>	<b>40,666.6</b>	

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР